

Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд нарын 202... оны дугаар сарын-ны өдрийн дугаар хамтарсан тушаалын хавсралт

СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧНЫ ЖУРАМ

/шинэчилсэн найруулгын төсөл/

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь санхүүгийн үйлчилгээнд шинээр нэвтэрч буй технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг Монгол улсын санхүүгийн зах зээлд нэвтрэхийг дэмжих зорилгоор Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк /цаашид “санхүүгийн зохицуулагч байгууллага” гэх/-ны хяналт, зохицуулалт дор хязгаарлагдмал хүрээг хамарсан бодит орчинд, тодорхой цаг хугацаанд турших боломжийг олгох сэндбоксыг зохицуулалтын орчин /цаашид “сэндбокс” гэх/-г бий болгох, оролцогчдод тавигдах шаардлагыг тодорхойлох, холбогдох харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Сэндбоксын зөвлөлийн дүрэм болон бусад баримт бичгийг санхүүгийн зохицуулагч байгууллагууд хамтран батална.
- 1.3. Сэндбоксад оролцогч нь санхүүгийн үйлчилгээг санал болгох бөгөөд энэхүү журмыг дагаж мөрдөнө.
- 1.4. Сэндбоксад оролцогчийн санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээ нь тусгай зөвшөөрөл шаардах үйл ажиллагаа байгаа тохиолдолд тусгай зөвшөөрөлд тавигдах шаардлагыг санхүүгийн зохицуулагч байгууллага зөвхөн өөрийн бүрэн эрхэд нийцэх хэмжээнд, сэндбокс хэрэгжих хугацаанд тухайн оролцогчийн хувьд бууруулах, эсхүл шаардлагаас чөлөөлөх байдлаар зохицуулж болно.

ХОЁР. ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 2.1. Сэндбоксын оролцогч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - 2.1.1. Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд байх;
 - 2.1.2. банк, санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн өр төлбөргүй;
 - 2.1.3. сэндбоксын хугацаанд үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй эрсдэлийг нөхөн төлөх санхүү, төлбөрийн чадвартай;
 - 2.1.4. хувьцаа эзэмшигчид, эрх бүхий албан тушаалтнууд нь мөнгө угаах болон эдийн засгийн гэмт хэрэг үйлдэж, гэм буруутай нь тогтоогдоогүй байх;
 - 2.1.5. хувьцаа эзэмшигчийн оруулж буй хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр нь Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан шаардлагыг хангасан.
- 2.2. Сэндбоксад дараах бүтээгдэхүүн үйлчилгээг хамруулна:

- 2.2.1. санхүүгийн зах зээлд шинээр нэвтэрч байгаа, эсхүл ижил төстэй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээтэй харьцуулахад хэрэглэгчдийн хүртэх үр ашгийг нэмэгдүүлсэн;
 - 2.2.2. шинээр нэвтрүүлж буй технологи, шийдэлтэй холбогдуулан зохицуулалтын орчин бүрдээгүй, эсхүл одоо байгаа зохицуулалтын орчинд өөрчлөлт оруулах шаардлага үүссэн;
 - 2.2.3. санхүүгийн зохицуулалтын орчинд шинээр нэвтэрч буй технологийн шийдэл буюу регтек;
 - 2.2.4. санхүүгийн зохицуулагч байгууллага болон бодлого гаргагчдын зүгээс тодорхой асуудлыг шийдвэрлэх зорилгоор санал болгосон бүтээгдэхүүн, үйлчилгээ болон бусад.
- 2.3. Сэндбоксын оролцогчийн санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээ нь дараах шаардлагыг хангасан байна:
- 2.3.1. санхүүгийн тогтвортой байдалд заналхийлээгүй;
 - 2.3.2. мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх чиглэлд ашиглагдах зорилго агуулаагүй;
 - 2.3.3. санхүүгийн үйлчилгээний хүртээмж болон хэрэглэгчдийн хүртэх үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн;
 - 2.3.4. хэрэгжих боломжтой байдал болон техник, эдийн засгийн үндэслэл, санхүүгийн үр ашгийн тооцоо хийгдсэн;
 - 2.3.5. энэхүү журмын 1 дүгээр хавсралтад заасан технологийн шаардлагыг хангасан байх;
 - 2.3.6. сэндбоксын хүрээнд хэрэглэгчдэд санал болгоход бэлэн болсон, технологийн хөгжүүлэлт нь шаардлагатай хэмжээнд хийгдсэн байх.
- 2.4. Сэндбоксад дараах бүтээгдэхүүн, үйлчилгээг хамруулахгүй:
- 2.4.1. технологийн шийдэл нь өрсөлдөх чадвар, хэрэглэгчдэд хүргэх үр ашиг багатай, шат дамжлага, зардал ихтэй, эсхүл санхүүгийн зах зээлд нэвтэрсэн;
 - 2.4.2. бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологийг зөвхөн турших зорилготой буюу цаашид зах зээлд нэвтрүүлэх, хөгжүүлэлт хийх зорилго агуулаагүй;
 - 2.4.3. энэхүү журмын 4.1-т заасан баримт бичгийн бүрдлийг хангаагүй, эсхүл ирүүлсэн баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн нь тогтоогдсон.
 - 2.4.4. хууль, эрх зүйн зохицуулалт, шаардлагаас зайлсхийх зорилго агуулсан.

ГУРАВ. СЭНДБОКСЫН ЗӨВЛӨЛ, АЛБА

- 3.1. Энэхүү журмын хэрэгжилтийг хангуулах чиг үүрэг бүхий Сэндбоксын зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ болон Сэндбоксын алба байна.
- 3.2. Зөвлөл нь дараах нэр бүхий байгууллагаас санал болгосон 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байна:

- 3.2.1. санхүүгийн зохицуулагч байгууллагын төлөөлөл;
 - 3.2.2. Сангийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон бусад төрийн байгууллагын төлөөлөл
 - 3.2.3. санхүү, мэдээлэл технологийн салбарын төлөөлөл;
 - 3.2.4. судлаач, эрдэмтэд.
- 3.3. Зөвлөл нь дараах үндсэн чиг үүргийн хэрэгжүүлнэ:
- 3.3.1. Сэндбоксын албанаас ирүүлсэн саналд үндэслэн сэндбоксын нөхцөл, хязгаарлалтыг тодорхойлж, сэндбоксоор оруулах эсэх зөвлөмжийг гарган холбогдох санхүүгийн зохицуулагч байгууллагад хүргүүлэх;
 - 3.3.2. сэндбокс дуусгавар болох үед холбогдох дүгнэлт, зөвлөмжийг гаргах;
 - 3.3.3. сэндбоксоор амжилттай туршигдсан бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд шаардлагатай зохицуулалтын, журам зааврын талаарх зөвлөмж гаргах;
 - 3.3.4. сэндбоксын үйл ажиллагаа болон технологид суурилсан ухаалаг санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд чиглэсэн бодлогын санал, зөвлөмж гаргах, дэмжлэг үзүүлэх.
- 3.4. Сэндбоксын албаны үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлнэ.
- 3.5. Сэндбоксын алба нь энэхүү журмын хэрэгжилтийг хангуулахдаа холбогдох санхүүгийн зохицуулагч байгууллагын хууль, мэдээллийн технологийн болон тухайн салбарын бодлого, хяналтын чиглэл хариуцсан албан хаагч /цаашид “чиглэл хариуцсан албан хаагч” гэх/-тай хамтран ажиллана.
- 3.6. Чиглэл хариуцсан албан хаагч нь бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөс хамааран сэндбоксоор орох хүсэлт ирэх тухай бүрд сонгогдон ажиллана.
- 3.7. Сэндбоксын алба нь Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны чиг үүрэгт зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
- 3.7.1. сэндбоксоор орох, гарах хүсэлтийг хүлээн авч, холбогдох судалгаа, шинжилгээг хийж чиглэл хариуцсан албан хаагчтай хамтран санал боловсруулан Зөвлөлд танилцуулах;
 - 3.7.2. оролцогчийн сэндбоксын хэрэгжилтийг үнэлэх гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, бизнес төлөвлөгөөтэй танилцан шаардлагатай тохиолдолд холбогдох саналыг тусгуулах;
 - 3.7.3. оролцогчдыг бүртгэн тэдгээрийн үйл ажиллагаанд чиглэл хариуцсан албан хаагчтай хамтран хяналт тавьж, зөвлөгөө өгч ажиллах;
 - 3.7.4. сэндбоксын үйл ажиллагаа болон технологид суурилсан санхүүгийн зах зээлийн талаар холбогдох судалгаа, шинжилгээг гүйцэтгэж, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх.

ДӨРӨВ. СЭНДБОКСОД ОРОХ ХҮСЭЛТ ГАРГАХ

- 4.1. Хүсэлт гаргагч нь дараах баримт бичгийг бүрдүүлж Сэндбоксын албанд ирүүлнэ:
- 4.1.1. сэндбоксоор орох хүсэлтээ илэрхийлсэн албан бичиг;
 - 4.1.2. энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу гаргасан өргөдөл;
 - 4.1.3. энэхүү журмын 4.3-т заасны дагуу боловсруулсан бизнес төлөвлөгөө;
 - 4.1.4. энэхүү журмын 4.4-т заасны дагуу боловсруулсан эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө;
 - 4.1.5. мэдээллийн аюулгүй байдлын журам;

- 4.1.6. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-д заасан этгээдүүд тус хуулийн 14.4-т заасан дотоод хяналтын хөтөлбөр;
- 4.1.7. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-д хамааралгүй этгээдүүд бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийг хэрэглэгчдэд хүргэх арга хэлбэр болон хэрэглэгчийг таньж мэдэх, эцсийн өмчлөгчийг тодорхойлж, эрсдэлийг бууруулахад чиглэсэн журам;
- 4.1.8. санхүүгийн тайлан;
- 4.1.9. Сэндбоксын албанаас шаардлагатай гэж үзсэн бусад баримт бичиг.
- 4.2. Хүсэлт болон холбогдох баримт, материалууд монгол хэл дээр байна. Гадаад хэл дээрх баримт, материалуудыг баталгаат орчуулгын хамт ирүүлнэ.
- 4.3. Бизнес төлөвлөгөө нь дараах шаардлагыг хангасан байна:
- 4.3.1. хүсэлт гаргагч болон түүний санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээний дэлгэрэнгүй танилцуулгыг тусгасан байх;
- 4.3.2. зорилго, зорилтуудыг нарийвчлан тусгасан, хэрэгжихүйц үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байх;
- 4.3.3. санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээ нь энэхүү журмын 2.3-т заасан шаардлагыг хангасан болохыг судалгаа, тооцооллын үр дүнгээр харуулж нотолсон байх;
- 4.3.4. зах зээлийн судалгаатай байх;
- 4.3.5. сэндбоксын хэрэгжилтийг үнэлэх гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт нь тодорхой байх;
- 4.3.6. сэндбокс амжилттай хэрэгжсэний дараагаар зах зээлд нэвтрэх шилжилтийн төлөвлөгөөтэй байх;
- 4.3.7. сэндбоксоос гарах төлөвлөгөөтэй байх.
- 4.4. Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө нь дараах шаардлагыг хангасан байна:
- 4.4.1. шаардлагатай тохиолдолд бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх хэрэглэгчдийн тоо, хамрах хүрээний хязгаарлалт, нэг хэрэглэгчдэд зөвшөөрөгдөх гүйлгээний тоо, эсхүл нэг удаагийн гүйлгээний дээд хэмжээг тогтоосон байх;
- 4.4.2. сэндбоксын үргэлжлэх хугацаанд хэрэглэгчдэд болон санхүүгийн зах зээлд үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлж урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан байх;
- 4.4.3. эрсдэл учирсан тохиолдолд хохирол барагдуулах санхүү, төлбөрийн чадвараа нотолсон байх;
- 4.4.4. маргаан шийдвэрлэх, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөтэй байх.
- 4.5. Сэндбоксын алба нь хүсэлтийг хүлээн авч хянах явцад хуулийн этгээдээс нэмэлт мэдээлэл шаардаж болно.
- 4.6. Сэндбоксын алба нь хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногт багтаан сэндбоксын шаардлагыг хангасан эсэхийг хүсэлт гаргагчдад албан бичгээр мэдэгдэнэ.

- 4.7. Хүсэлт гаргагч нь хүсэлт гаргаснаас хойш товлосон хугацаанд бизнес төлөвлөгөө, бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологийн шийдлээ Сэндбоксын алба болон Зөвлөлд биечлэн танилцуулна.
- 4.8. Зөвлөл нь сэндбоксад оролцох хүсэлт, холбогдох материал болон Сэндбоксын албанаас ирүүлсэн саналд үндэслэн сэндбоксын нөхцөл, хязгаарлалтыг тодорхойлж, сэндбоксад оруулах эсэх зөвлөмжийг холбогдох санхүүгийн зохицуулагч байгууллагад ажлын 10 хоногт хүргүүлнэ.

ТАВ. ХЭРЭГЛЭГЧИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

- 5.1. Оролцогч нь бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хэрэглэгчдэд санал болгохдоо дараах нөхцөлийг заавал мэдэгдэнэ:
 - 5.1.1. бүтээгдэхүүн, үйлчилгээг сэндбоксын орчинд санал болгож буй бөгөөд санхүүгийн зохицуулагч байгууллагаас тухайн үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл аваагүй болох талаар;
 - 5.1.2. хэрэглэгчид учирч болох эрсдэлийг танилцуулж энэ талаарх бүртгэл, тэмдэглэл хөтлөх;
 - 5.1.3. хэрэглэгч санхүүгийн хохирол хүлээсэн тохиолдолд буцаан олгох нөхөн олговрын хэмжээг харилцан тохиролцсон байх;
 - 5.1.4. санхүүгийн зохицуулагч байгууллага нь оролцогчдын бусдын өмнө хүлээх үүргийг хариуцахгүй болохыг мэдэгдсэн байх.
- 5.2. Энэхүү журмын 5.1-д заасан бүтээгдэхүүн, үйлчилгээний санал нь хэрэглэгчийг төөрөгдүүлэхүйц, хоёрдмол утга агуулаагүй, энгийн үг хэллэг ашиглах бөгөөд хэрэглэгч уншиж ойлгосны үндсэн дээр тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээ авах шийдвэрийг өөрөө, бие даан гаргана.
- 5.3. Оролцогч нь хэрэглэгчийн зөвшөөрлийг бичгээр, эсхүл цахимаар авна.
- 5.4. Санхүүгийн зохицуулагч байгууллага нь хэрэглэгчдийн эрхийг хамгаалах зорилгоор оролцогчдод дараах хязгаарлалтуудаас аль тохирохыг, шаардлагатай бол бүгдийг тавина:
 - 5.4.1. заавал байлгах нөөц хөрөнгийн хэмжээг тогтоох;
 - 5.4.2. бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох зах зээлийн хүрээ, хэрэглэгчдийн тоо, нутаг дэвсгэр, нэг удаад, эсхүл нийт хийгдэх гүйлгээний тоо, хэмжээнд хязгаарлалт тогтоох;
 - 5.4.3. хохирол нөхөн төлөхөд шаардлагатай хөрөнгийн доод хэмжээг тогтоох;
 - 5.4.4. бүтээгдэхүүн, үйлчилгээний онцлогоос хамааран шаардлагатай гэж үзсэн бусад.
- 5.5. Оролцогч нь сэндбоксын орчинд хэрэглэгчид болон тэдгээрт хүргэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар тогтмол бүртгэж, мэдээллийн сан үүсгэж нууцлалын аюулгүй байдлыг ханган ажиллана.
- 5.6. Сэндбоксын туршилт амжилтгүй болсон тохиолдолд оролцогч нь сэндбоксын орчинд цуглуулсан хэрэглэгчдийн бүх мэдээллийг задруулахгүйгээр устгана.
- 5.7. Санхүүгийн зохицуулагч байгууллага нь сэндбоксын ил тод байдал болон хэрэглэгчийг мэдээллээр хангах үүднээс оролцогчийн нэр, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүн, үйлчилгээний танилцуулга, сэндбоксын эхлэх, дуусах хугацааг өөрийн цахим хуудсанд нийтэлсэн байна.
- 5.8. Санхүүгийн зохицуулагч байгууллага нь оролцогчийн мэдээллийг биет болон оюуны өмчийн эрхэд халдахгүйгээр нийтлэх эрхтэй.

- 5.9. Санхүүгийн зохицуулагч байгууллага нь хүсэлт гаргагч болон оролцогчидтой холбоотой аливаа мэдээллийн нууцлал аюулгүй байдлыг ханган, бусад зорилгоор ашиглахыг хориглоно.

ЗУРГАА. СЭНДБОКСОД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ

- 6.1. Оролцогч нь энэхүү журмын 4.1.3, 4.1.4 -д заасан баримт бичгүүдийг Зөвлөлийн болон Сэндбоксын албаны саналыг тусгаж эцэслэн боловсруулна.
- 6.2. Санхүүгийн зохицуулагч байгууллага нь Зөвлөлийн дүгнэлтэд үндэслэн сэндбоксоод туршиж буй бүтээгдэхүүн, үйлчилгээнд нэмэлт шаардлага, хязгаарлалтуудыг тавьж болно.
- 6.3. Оролцогч нь сэндбоксоод туршигдаж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний тайлан, мэдээг улирал бүрийн дараа сарын эхний 10 хоногт ирүүлнэ. Шаардлагатай тохиолдолд бүтээгдэхүүн, үйлчилгээний онцлогоос хамааруулан сарын мэдээг дараа сарын 5-ны дотор ирүүлнэ.
- 6.4. Тайлан нь дараах шаардлагыг хангасан байна.
- 6.4.1. тайлангийн агуулга хэлбэр, бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой статистик мэдээлэл, параметруудийг урьдчилан тодорхойлж тайланг ойлгомжтой байдлаар боловсруулах;
- 6.4.2. туршилтын явцад гарсан гомдол маргаан болон техникийн гэмтлийг тухай бүрд бүртгэж, шийдвэрлэсэн байдлыг дэлгэрэнгүй тусгах;
- 6.4.3. туршилтын явцад нийгэм, эдийн засаг, хууль эрх зүйн орчны өөрчлөлтөөс шалтгаалан хүндрэл бэрхшээл үүссэн бол түүнийг шийдвэрлэх хариу арга хэмжээг тусгах;
- 6.4.4. туршиж буй бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой дэлгэрэнгүй орлого, үр дүнгийн тайлан.
- 6.5. Оролцогчийн өргөдөлд бөглөсөн мэдээлэл болон хэрэглэгчидтэй байгуулах гэрээ, холбогдох баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд ажлын 10 хоногт шинэчлэгдсэн мэдээллийг Сэндбоксын албанд ирүүлнэ.
- 6.6. Оролцогч нь сэндбокс үргэлжлэх хугацаанд бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загвар, шилжих болон гарах төлөвлөгөөг тогтмол сайжруулж ажиллана.
- 6.7. Оролцогч нь бизнес төлөвлөгөөнд дараах өөрчлөлтийг оруулж болно:
- 6.7.1 сэндбоксоод туршиж буй бүтээгдэхүүнтэй ижил төрлийн бүтээгдэхүүнийг нэмж санал болгох;
- 6.7.2 туршилтын явцад үүссэн нөхцөл байдлаас шалтгаалан бизнес загварыг өөрчлөх.
- 6.8. Оролцогч нь бизнес төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах хүсэлтийг Сэндбоксын албанд ирүүлэх ба Зөвлөл нь Сэндбоксын албаны дүгнэлтэд үндэслэн холбогдох зөвлөмжийг санхүүгийн зохицуулагч байгууллагад 30 хоногт хүргүүлнэ. Санхүүгийн зохицуулагч байгууллага холбогдох шийдвэрийг ажлын 10 хоногт гаргана.
- 6.9. Оролцогчдод зайны болон газар дээрх хяналт, шалгалтыг холбогдох санхүүгийн зохицуулагч байгууллагын хяналт шалгалтын нэгж хэрэгжүүлэх ба Сэндбоксын алба хамтран оролцоно.
- 6.10. Сэндбоксын үргэлжлэх хугацаа 1 жил хүртэлх байх ба оролцогчдын хүсэлтийг үндэслэн 1 жил хүртэлх хугацаагаар нэг удаа сунгаж болно.
- 6.11. Оролцогч нь сэндбоксын үргэлжлэх хугацааг сунгах хүсэлтийг хугацаа дуусгавар болохоос 30-аас доошгүй хоногийн өмнө Сэндбоксын албанд хүргүүлнэ.

- 6.12. Зөвлөл нь оролцогчийн хүсэлтэд үндэслэн холбогдох зөвлөмжийг 30 хоногт багтаан санхүүгийн зохицуулагч байгууллагад хүргүүлнэ. Санхүүгийн зохицуулагч байгууллага холбогдох шийдвэрийг ажлын 10 хоногт гаргана.
- 6.13. Оролцогч нь сэндрбоксын үргэлжлэх хугацаанд зөвшөөрөгдсөнөөс бусад бүтээгдэхүүн үйлчилгээг туршихыг хориглоно.

ДОЛОО. СЭНДБОКСООС ГАРАХ

- 7.1. Оролцогчийг дараах тохиолдлуудад сэндрбоксоос гаргана:
- 7.1.1. сэндрбоксын үргэлжлэх хугацаа дууссан;
 - 7.1.2. сэндрбоксын үргэлжлэх хугацааг санхүүгийн зохицуулагч байгууллагын шийдвэрээр, эсхүл оролцогчийн хүсэлтээр хугацаанаас өмнө дуусгавар болгосон.
- 7.2. Дараах тохиолдолд оролцогчийг хугацаанаас өмнө сэндрбоксоос гаргана:
- 7.2.1. Зах зээлийг урвуулан ашиглаж хэрэглэгчийг хохироох буруутай үйл ажиллагаа явуулсан, эрх бүхий албан тушаалтнууд нь мэргэжлийн болон ёс зүйн зөрчил гаргасан;
 - 7.2.2. оролцогч нь санхүүгийн зохицуулагч байгууллагаас тогтоосон нөхцөл, хязгаарлалтыг зөрчсөн;
 - 7.2.3. оролцогч нь бусдыг төөрөгдүүлсэн, буруу ташаа мэдээлэл өгсөн, эсхүл мэдээллийг нуун дарагдуулсан нь илт болсон, мэдээллийн аюулгүй байдал, нууцлалын шаардлагыг зөрчсөн;
 - 7.2.4. оролцогчийн санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээ нь энэхүү журмын 2.3-т заасан шаардлагад нийцэхгүй болсон;
 - 7.2.5. оролцогчийн үйл ажиллагаанаас үүдсэн гомдол, зөрчил, эсхүл технологийн эвдрэл гэмтлийг засаж сайжруулах боломжгүй тохиолдолд;
 - 7.2.6. бусад.
- 7.3. Оролцогч хугацаанаас өмнө өөрийн хүсэлтээр гарах хүсэлтээ Сэндрбоксын албанд хүргүүлэх ба оролцогчийн хүсэлтэд үндэслэн Зөвлөл зөвлөмжийг ажлын 10 хоногт багтаан санхүүгийн зохицуулагч байгууллагад хүргүүлнэ. Санхүүгийн зохицуулагч байгууллага холбогдох шийдвэрийг ажлын 10 хоногт гаргана.
- 7.4. Оролцогчийг хугацаанаас нь өмнө сэндрбоксоос гаргах тохиолдолд 30 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэх ба шалтгаан, шийдвэрийг дэлгэрэнгүй байдлаар хүргүүлнэ.
- 7.5. Санхүүгийн тогтвортой байдал, оролцогч, хэрэглэгчийг хамгаалах зайлшгүй шаардлага үүссэн нөхцөлд зохицуулагч байгууллага нь урьдчилан мэдэгдэлгүйгээр тухайн оролцогчийг сэндрбоксоос гаргах эрхтэй.
- 7.6. Оролцогч сэндрбоксын туршилтын хугацаа дуусгавар болох үед 30-аас доошгүй хоногийн өмнө гарах хүсэлтээ Сэндрбоксын албанд хүргүүлэх ба оролцогчийн хүсэлтэд үндэслэн Зөвлөл зөвлөмжийг 30 хоногт багтаан гаргана.
- 7.7. Оролцогчийн сэндрбоксын туршилт нь Зөвлөлөөр амжилтгүй гэж дүгнэгдсэн тохиолдолд санхүүгийн зохицуулагч байгууллагын шийдвэрийн дагуу энэхүү журмын 4.3.7, 4.4.4-д заасан төлөвлөгөөг хэрэгжүүлж дараах арга хэмжээг нэн даруй авна:
- 7.7.1. хэрэглэгчдэд үйл ажиллагаа дуусгавар болсон талаар мэдэгдэх;
 - 7.7.2. үүссэн аливаа маргааныг шийдвэрлэх;
 - 7.7.3. хэрэглэгчийн санхүүгийн хохирлыг тохиролцсон дүнгээр нөхөн барагдуулах.
- 7.8. Оролцогчийн сэндрбоксын туршилт нь Зөвлөлөөр амжилттай буюу цаашид зах зээлд нэвтрэх боломжтой гэж дүгнэгдсэн тохиолдолд шилжих төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.

Шилжих үе шат нь 6 сар хүртэлх хугацаа байх ба сэндрбоксоос тогтоосон зарим нөхцөл, шаардлага, хязгаарлалтууд хүчин төгөлдөр хэрэгжинэ.

- 7.9. Шилжилтийн хугацаа дуусгавар болох үед санхүүгийн зохицуулагч байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу оролцогч сэндрбоксоос гарна.
- 7.10. Оролцогч сэндрбоксоос гарснаас хойш 30 хоногт багтаан санхүүгийн зохицуулагч байгууллагад дараах тайлангуудыг ирүүлнэ:
 - 7.10.1. сэндрбоксоос гарах, эсхүл шилжих төлөвлөгөөнд заасан арга хэмжээний тайлан;
 - 7.10.2. сэндрбоксоод оролцсоноор гарсан үр дүн, хэрэглэгчид тухайн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар хэрхэн хүлээж авсан, хэрэглэгчтэй холбоотой гомдол, маргаан сэндрбоксын хугацаанд гарсан бол түүнийг хэрхэн шийдсэн, хэрэв сэндрбоксын туршилт амжилтгүй болсон бол түүний шалтгаан, үр дагаврын талаарх мэдээлэл бүхий тайлан.
- 7.11. Сэндрбоксын алба, чиглэл хариуцсан албан хаагчтай хамтран сэндрбоксоос гарах, эсхүл шилжих төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавина.
- 7.12. Оролцогч сэндрбоксоос гарах үед сэндрбоксын хүрээнд үйлчилж байсан санхүүгийн зохицуулагч байгууллагаас тогтоосон нөхцөл, шаардлага, хязгаарлалтууд хүчингүй болно.
- 7.13. Санхүүгийн зохицуулагч байгууллага нь сэндрбоксоод амжилттай хэрэгжсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг бий болгох талаар холбогдох төрийн байгууллагуудтай хамтран ажиллана.

НАЙМ. БУСАД

- 8.1. Сэндрбоксоод оролцож байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээнээс үүдэн хэрэглэгчдэд үүссэн хохирлыг оролцогч тал дангаараа хариуцна.
- 8.2. Санхүүгийн зохицуулагч байгууллага нь оролцогчид болон олон нийтийг сэндрбоксын зохицуулалтын талаарх зөвлөгөө, мэдээллээр тогтмол хангаж ажиллана.

Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд нарын 202... оны дугаар сарын-ны өдрийн дугаар хамтарсан тушаалаар баталсан “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ын нэгдүгээр хавсралт

СЭНДБОКСЫН ОРОЛЦОГЧДОД ТАВИГДАХ ТЕХНОЛОГИЙН ШААРДЛАГА

Сэндбоксод оролцохоор хүсэлт гаргаж буй хуулийн этгээд нь дараах технологийн шаардлагуудыг хангасан байна:

- Tier 2 стандартын дата төвтэй эсвэл энэхүү стандартыг хангасан дата төвд системийг байршуулсан байх;
- Хэрэглэгчийн мэдээллийг нийтийн болон хувийн сүлжээгээр дамжуулахдаа шифрлэн нууцалсан байх;
- Албан ёсны эрх бүхий вирусээс хамгаалах программ хангамж ашигладаг байх;
- Нууцлал, аюулгүй байдлын систем болон программ хангамж хөгжүүлж ашигласан байх;
- Хэрэглэгчийн мэдээлэлд нэвтэрч буй бүх хандалтыг хянаж, бүртгэлжүүлдэг байх;
- Аюулгүй байдлын туршилт (Penetration Test)-ыг стандартын дагуу хийсэн байх;
- ITIL эсвэл Cobit 4.1 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байх;

Сэндбоксод оролцохоор хүсэлт гаргаж буй хуулийн этгээд нь өөрийн санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээний онцлог, технологийн шийдэлд тохируулан дараах материалуудыг Сэндбоксын алба, Зөвлөлд ирүүлнэ. Үүнд:

- Ашиглаж буй технологи, тоног төхөөрөмжийн жагсаалт, танилцуулга;
- Хэрэглэгч болон сервер талуудыг хамруулсан сүлжээ болон программ хангамжийн бүтэц схем (topology schema);
- Технологи хариуцсан алба, ажилчдын чиг үүрэг, танилцуулга;
- Систем хөгжүүлэлтийн зардал;
- Өгөгдлийн санд ашигласан технологийн мэдээлэл;
- Систем хооронд ашиглагдаж буй сервисийн жагсаалт;
- Систем, хэрэглэгч болон үйл ажиллагааны гарын авлагууд;
- Системийн ачаалал даах чадварын тайлан;
- Нууцлал, аюулгүй байдлыг хангах хүрээнд хийгдсэн ажлын жагсаалт;
- ISO27001 стандарт эсвэл CISA сертификатын дагуу гүйцэтгэсэн аудитын тайлан.

Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд нарын 202. оны дугаар сарын-ны өдрийн дугаар хамтарсан тушаалаар баталсан “Сэндбокс зохицуулалтын орчны журам”-ын хоёрдугаар хавсралт

СЭНДБОКСОД ОРОХ ХҮСЭЛТ ГАРГАХ ӨРГӨДЛИЙН МАЯГТ

I. СЭНДБОКСОД ОРОЛЦОГЧИЙН ТУХАЙ			
Оролцогч байгууллагын мэдээлэл			
Байгууллагын нэр, бүртгэлийн дугаар:			
Тусгай зөвшөөрөл эзэмшдэг бол тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар:			
Байгууллагын хаяг:			
Холбоо барих утас:			
И-мэйл хаяг:			
Цахим хуудас:			
Үүсгэн байгуулагдсан огноо:			
Ажиллагсдын тоо:			
Хөрөнгө оруулалтын хэлбэр:		<input type="checkbox"/> Дотоодын хөрөнгө оруулалттай <input type="checkbox"/> Гадаадын хөрөнгө оруулалттай	
Үйл ажиллагаа явуулах чиглэл, зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл:			
Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл			
Овог нэр/ оноосон нэр	Хувьцааны тоо	ХНХ-ийн хэмжээ (₮)	ХНХ-д эзлэх хувь
Байгууллагын эрх бүхий албан тушаалтны мэдээлэл			
Овог, нэр:			
Албан тушаал:			
Эзэмшсэн боловсрол, мэргэжил:			
Холбоо барих утас:			
И-мэйл хаяг:			
Өргөдлийн маягыг бөглөж буй ажилтны мэдээлэл			
Өргөдөл гаргаж буй ажилтны овог, нэр:			
Албан тушаал:			

Холбоо барих утас:	
И-мэйл хаяг:	
Сэндбокс үргэлжлэх хугацаанд өөр байгууллагатай хамтран ажиллах бол тухайн байгууллагын мэдээлэл	
Байгууллагын нэр, бүртгэлийн дугаар:	
Тусгай зөвшөөрөл эзэмшдэг бол тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар:	
Байгууллагын хаяг:	
Холбоо барих утас:	
И-мэйл хаяг:	
Цахим хуудас:	
Үүсгэн байгуулагдсан огноо:	
Ажилчдын тоо:	
Хөрөнгө оруулалтын хэлбэр:	<input type="checkbox"/> Дотоодын хөрөнгө оруулалттай <input type="checkbox"/> Гадаадын хөрөнгө оруулалттай
Үйл ажиллагаа явуулдаг чиглэл:	
2. СЭНДБОКСОД ОРОХ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ, ТЕХНОЛОГИЙН ШИЙДЛИЙН ТАЛААР	
А. Сэндбоксад орох бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийн бусдаас ялгарах онцлогийг товч тайлбарлан бичнэ үү.	
Б. Сэндбоксад орох бүтээгдэхүүн, үйлчилгээнээс хүлээж буй үр дүн мөн ашиглаж буй технологи нь хөгжүүлэлтийн үе шатны аль хэсэгт явж буй талаар бичнэ үү.	
В. Сэндбоксад орох бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэлэг байдал, санхүүгийн зах зээл, тэдгээрт оролцогчдын үр ашиг, өгөөжийг хэрхэн нэмэгдүүлэх талаар бичнэ үү.	

Г. Сэндбоксоод орох бүтээгдэхүүн үйлчилгээний өрсөлдөгчдөөс ялгарах онцлогийг бичнэ үү.

Д. Технологийн хувьд гарч болзошгүй эрсдэл, түүнээс үүдэж болох хохирлыг хэрхэн бууруулах талаар төлөвлөгөөгөө товч бичнэ үү.

Е. Сэндбоксын хүрээнд танай бүтээгдэхүүн, үйлчилгээг амжилттай хэрэгжүүлэхийн тулд зохицуулагч байгууллагын зүгээс ямар зохицуулалт хийх шаардлагатай гэж харж байна вэ ?

3. СЭНДБОКСОД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

А. Сэндбоксоод орох хэрэгцээ шаардлагыг тодорхойлно уу.

Б. Сэндбоксоос амжилттай хэрэгжсэн эсэхийг үнэлэх хэмжих үзүүлэлт байгаа бол түүний талаар бичнэ үү.

В. Сэндбоксоос хүлээж буй үр өгөөжийн талаар бичнэ үү.

Г. Сэндбоксоод орох бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэх зорилтот хэрэглэгчид, зах зээлийн талаар товч бичнэ үү.

Д. Сэндбоксоос гарах төлөвлөгөөний талаар товч бичнэ үү.

Е. Хэрэв бүтээгдэхүүн үйлчилгээ сэндбоксоос амжилттай гарвал дараагийн алхам юу байх вэ?